

Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага

Гүний худгийн ажил

№	Ажлын нэр
1	Цооногын ашиглалтын ундарга: 0.8л/с ба түүнээс дээш
2	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
3	Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
4	Ус өргөх яндангийн диаметр 25мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/
5	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцорын хольцгүй, мөхлөгийн хэмжээ нь 10-15мм-ээс томгүй байна
6	Тунгаагуурын гүн нь 2м-ээс багагүй.
7	Усны чанарын сорил авах, шинжэлгээ хийлгэх

Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих

№	Ажлын нэр
1	<p>Худгийн байшингийн</p> <ul style="list-style-type: none"> - Хэмжээ /доод талдаа/: 3 х 3м, ханийн өндөр шалнаас дээш 2м. - Тоосго, блок, модон, - Контейнэр байж болно - Ханын зузаан 38см - Ханыг дотор талаас нь шавардаж өнгийн будгаар будна. - Цооногийн дээд харалдаа 30х30см хэмжээтэй нээлхийг тохируулна хийнэ. Нээлхийг худгийг завсарлахад хэрэглэнэ. - Худгийн цонх 40х50см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. Цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана.
2	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь 60мм диаметртэй, гаднах хананаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах.
3	Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй ган хоолойг цонхны доор гаргах. /ундны ус авах тохиромжтой байдлаар уртыг сонгох/
4	40мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд тохируулан тохиромжтой байрлалд гаргана.
5	Босоо суурьтай, тоноглон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1.5м ³ –ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай.
6	<p>Мал услах онгоцны:</p> <ul style="list-style-type: none"> - Хэмжээ 9м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой хагас цилиндр - Материал: ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетон - Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. - Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхийг гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эргэдэж хаадаг байхаар хийнэ. - Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг

	усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхаж гаргахаар байрлуулж гаргана. - Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.
7	Мал услах талбай нь: - Хэмжээ: нийт уртын дагуу 2 талдаа 2м-ийн өргөнтэй зузаан нь 10см - Материал: 150 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэж өгнө. - Улсах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэхэд тохиромжтой байна.

Худгийн насос, генератор, цахилгааны утас хянах самбар

№	Ажлын нэр
1	Гүний насос: ISO-9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглахад боломжтой байх.
2	Цахилгаан утас: 3 салаа, худаг ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн, залгаасгүй, ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно. /туузаар ороож болохгүй/
3	Хянах самбар: асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай байна.
4	Генератор: бензинээр ажилладаг, /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.